



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/01

Мандалговь

Хэвлэмэл хуудасны индекс батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Архивын тухай хуулийн 9.4.1, Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх хэрэглэх заавар”-ын 38, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам”-ын 4.4, 4.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ажилд хэрэглэх хэвлэмэл хуудасны нэр төрөл, тэдгээрийн индексийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060002

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн
А/11. дүгээр тушаалын хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
ХЭРЭГЛЭХ ХЭВЛЭМЭЛ ХУУДАСНЫ НЭР ТӨРӨЛ,
ТЭДГЭЭРИЙН ИНДЕКС

№	Хэвлэмэл хуудасны нэр төрөл	Хэвлэмэл хуудасны индекс	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Аймгийн Засаг даргын захирамж	48120(0000)	Засаг даргын туслах
2	Аймгийн Засаг даргын албан даалгавар	48220(0000)	Засаг даргын туслах
3	Зөвлөлийн хурлын тэмдэглэл	48320(0000)	ТЗУХ-ийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
4	Аймгийн Засаг даргын албан бичгийн хэвлэмэл хуудас А4	48420(0000)	ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч
5	Аймгийн Засаг даргын албан бичгийн хэвлэмэл хуудас А5	48520(0000)	ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал	48620(0000)	ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч
7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан бичгийн хэвлэмэл хуудас А4	48720(0000)	ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч
8	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан бичгийн хэвлэмэл хуудас А5	48820(0000)	ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч